ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

“Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан

2026 он

“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2026.07.04

НЭГ. ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

"Иргэний нисэхийн үндэсний төв" (ИНҮТ) ТӨХХК, түүний дотоод бүтцийн нэгж, салбар нэгж болон орон нутгийн нисэх буудлуудын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулан гүйцэтгэх удирдлагад танилцуулах зорилгоор энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар батлагдсан "Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам"-ыг үндэслэн хэрэгжилтийн түвшин, үр дүн, тайлагналын чанарт үнэлгээ хийлээ.

ХОЁР. ТАНИЛЦУУЛГА

2026 оны эхний хагас жилийн байдлаар "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК нь нийт **9 зорилтын хүрээнд 53 арга хэмжээ** төлөвлөснөөс хэрэгжилтийн дундаж **74.3 хувь** буюу **"Үр дүн хүлээгдэж байгаа"** түвшинд үнэлэгдсэн байна. Харин дотоод бүтцийн нэгж, салбар нэгж, орон нутгийн нисэх буудлуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дундаж хэрэгжилт **84.6 хувь** байгаа нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны хэрэгжилт ерөнхийдөө тогтвортой байгааг харуулж байна.

Зорилтуудын хэрэгжилтийг харьцуулан үзэхэд "Нисэх буудлуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах" зорилт 97.5 хувь-ийн хэрэгжилттэйгээр хамгийн өндөр үнэлэгдсэн бол "Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээнд аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлэх" (87.5%), "Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах" (88.3%), "Баримт бичиг, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах" (87.5%) зорилтууд харьцангуй сайн хэрэгжилттэй байна.

Харин "Компанийн санхүүг үр ашигтай удирдах, үр ашгийг нэмэгдүүлэх" (55.0%), "Агаарын навигацийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах" (57.8%) зэрэг зорилтын хэрэгжилт байгууллагын дундаж үзүүлэлтээс үлэмж доогуур байгаа нь эдгээр чиглэлээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, удирдлагын түвшний анхаарал хандуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Дотоод бүтцийн нэгжүүдийн хэрэгжилтийг авч үзвэл Оношилгоо, хэмжилзүйн лаборатори (99.6%), Гадаад харилцааны хэлтэс (98.8%), Төслийн нэгдсэн удирдлагын газар (97.0%), Агаарын навигацийн үйлчилгээний газар (96.0%), Нисэх буудлуудын үйлчилгээний газар (96.0%), Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба (96.3%) зэрэг нэгжүүд төлөвлөсөн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. Энэ нь тухайн

нэгжүүдийн төлөвлөлт, хэрэгжилтийн уялдаа, гүйцэтгэлийн хяналт, удирдлагын зохион байгуулалт харьцангуй сайн байгааг илтгэж байна.

Харин Худалдан авах ажиллагааны алба (54.1%), Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх хэлтэс (67.0%), Баянхонгор нисэх буудал (67.8%), Булган нисэх буудал (70.7%), Буянт-Ухаа олон улсын нисэх буудал (71.2%), Нисэхийн аюулгүйн хамгаалалтын газар (71.4%), Өндөрхаан нисэх буудал (72.5%), Мөрөн болон Чойбалсан нисэх буудал (74.2%) зэрэг нэгжүүдийн хэрэгжилт байгууллагын дундаж түвшнээс доогуур байгаа нь төлөвлөсөн ажлын гүйцэтгэл удааширсан, зарим арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байгааг харуулж байна.

Мөн үнэлгээнээс харахад олон нэгжийн тайланд **"хэрэгжих шатандаа"** болон **"хугацаа болоогүй"** ангилалд багтсан арга хэмжээний эзлэх хувь өндөр байна. Энэ нь зарим тохиолдолд төлөвлөгөө боловсруулахдаа хугацааны оновчтой хуваарилалт, хэрэгжилтийн үе шат, шалгуур үзүүлэлтийг бодитой тодорхойлоогүйтэй холбоотой гэж үзэхээр байна.

Байгууллагын үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой зорилтуудын хэрэгжилт харьцангуй өндөр байгаа боловч санхүүгийн үр ашиг, худалдан авах ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг удирдлага, дэмжих чиг үүргийн хэрэгжилт сул байгаа нь байгууллагын нийт гүйцэтгэлийн үр нөлөөнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Иймд хоёрдугаар хагас жилд хэрэгжилт сул байгаа зорилт, нэгжүүдэд удирдлагын түвшний хяналт, зохицуулалтыг нэмэгдүүлж, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

"ИНҮТ" ТӨХХК-ийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт, арга хэмжээгээр нь нэгтгэн харуулбал:

ЗОРИЛТ	АРГА ХЭМЖЭЭ	ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ
Зорилт 1. Агаарын навигацийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна	9	57.8%
Зорилт 2. Нисэх буудлуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	14	97.5%
Зорилт 3. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	7	88.3%
Зорилт 4. Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээнд аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцоог үр нөлөөтэйгөөр хэрэгжүүлж, сайжруулна	4	87.5%
Зорилт 5. Компанийн санхүүг үр ашигтай удирдан зохион байгуулан, үр ашгийг дээшлүүлж, орлого нэмэгдүүлнэ	4	55,0%
Зорилт 6. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангана	4	72.5%
Зорилт 7. Баримт бичиг, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангана	7	87.5%
Зорилт 8. Компанийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ	2	50,0%
Зорилт 9. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ	2	75,0%
Хэрэгжилт дундаж хувь	**53 ажил**	**74,3%**

Газар, албадын нэр	Төлөвлөсөн нийт ажил	Үүнээс				Хэрэгжилт хувиар
		100%	Хэрэгжих шатандаа	0%	Хугацаа болоогүй	
"ИНҮТ"ТӨХХК	53	27	17	3	6	74,3%

"ИНҮТ" ТӨХХК болон түүний дотоод бүтцийн нэгж, салбар нэгжүүд, орон нутгийн нисэх буудлууд 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Газар, албадын нэр	Төлөвлөсөн нийт ажил	Үүнээс				Хэрэгжилт хувиар
		100%	Хэрэгжих шатандаа	0%	Хугацаа болоогүй	
Гүйцэтгэлийн төлөвлөгөө гаргаж дүгнүүлэх албан тушаалтнууд						
Үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан менежер	32	17	8	2	5	82.2%
Бодлого, төлөвлөлт хариуцсан менежер	18	11	5	-	2	86,8%
"ИНҮТ" ТӨХХК болон түүний дотоод бүтцийн нэгжүүд						
Аюулгүй байдал, чанарын удирдлагын газар	14	8	4	-	2	88,3%
Агаарын навигацийн үйлчилгээний газар	41	29	3	2	7	96,0%
Нисэх буудлуудын үйлчилгээний газар	24	19	2	-	3	96,0%
Нисэхийн аюулгүйн хамгаалалтын газар	24	8	13	1	2	71,4%
Захиргаа, санхүү удирдлагын газар	33	18	12		3	80,6%
Төслийн нэгдсэн удирдлагын газар	7	4	1	-	2	97,0%
Бодлого, төлөвлөлтийн газар	21	8	11	-	2	80,5%
Хамтын ажиллагааны газар	18	14	3	-	1	90,0%
Захиалагчийн хяналтын газар	Тусдаа төлөвлөгөөгүй байхгүй.					
Захиргаа, хууль, эрх зүйн хэлтэс	50	30	12	-	8	84,4%
Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс	12	5	5	-	2	80,0%
Эдийн засгийн төлөвлөлтийн хэлтэс	Тусдаа төлөвлөгөө байхгүй					
Гадаад харилцааны хэлтэс	15	12	1	-	2	98,8%
Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх хэлтэс	11	3	3	2	3	67,0%
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс	34	29	1	4	-	87,4%
Эрэн хайх, авран туслах ажиллагааны мэдээлэл зохицуулах төв	21	16	1	1	3	93,8%
Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба	19	10	5	-	4	83,8%
Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба	42	23	13	-	6	90,2%

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба	46	21	13	2	10	81,2%
Нислэгийн журам зохиолт, шалгалтын нислэгийн алба	36	9	5	4	18	82,0%
Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба	24	15	5	-	3	92,3%
"Сайншанд" агаарын навигацийн төв	6 сард шинээр байгуулагдсан төлөвлөгөө байхгүй.					
Буянт-Ухаа ОУНБ	42	23	1	9	9	71,2%
Аэродром, гэрэл суултын алба	19	15	1	-	3	95,6%
Оношилгоо, хэмжилзүйн лаборатори	25	24	1	-	-	99,6%
Нисэхийн аюулгүй байдал, хамгаалалтын байдал	21	15	4	-	2	93,2%
Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба	8	7	1	-	-	96,3%
Нисэхийн сургалтын төв						
Худалдан авах ажиллагааны алба	18	6	7	4	1	54,1%
Нисэхийн спорт цогцолбор	16	14	2	-	-	92,5%
Барилга байгууламжийн ашиглалтын алба	14	12	2	-	1	94,6%
"Жаргалант" сэргээн засах амралт	17	12	4	-	1	85,0%
Алтай НБ	44	36	2	1	5	95,9%
Арвайхээр НБ	24	20	1	2	1	93,0%
Баруун-Урт НБ	34	27	1	2	4	91,7%
Баянхонгор НБ	48	29	3	13	3	67,8%
Булган НБ	15	9	2	3	1	70,7%
Гурвансайхан НБ	45	33	3	7	2	81,4%
Дэглийцагаан НБ	33	25	-	6	2	80,6%
Мандалговь НБ	35	29	1	4	1	87,6%
Мөрөн НБ	32	22	2	7	1	74,2%
Отгонтэнгэр НБ	27	24	1	1	1	91,5%
Өлгий НБ	34	27	4	2	1	87,6%
Өндөрхаан НБ	26	14	1	5	6	72,5%
Тосонцэнгэл НБ	24	15	2	3	4	80,0%
Ховд НБ	35	26	2	6	1	79,4%
Чойбалсан НБ	41	22	5	6	8	74,2%
Хэрэгжилт дундаж хувь						**84,6%**

ГУРАВ. ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

"ИНҮТ" ТӨХХК болон түүний дотоод бүтцийн нэгж, салбар нэгж, орон нутгийн нисэх буудлуудын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан үзэхэд төлөвлөлт нь Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан *"Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"*-д заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Тухайлбал, гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллагын стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны зорилго, бусад бодлогын баримт бичигтэй уялдсан, хүрэх үр дүн, зорилтот түвшин, хэмжих шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц байдлаар төлөвлөгдөх ёстой боловч зарим нэгжийн төлөвлөгөөнд эдгээр шаардлага хангалтгүй тусгагдсан байна.

Мөн дотоод бүтцийн нэгжүүд болон орон нутгийн нисэх буудлууд арга хэмжээ тус бүрийг хариуцах нэгж, албан тушаалтныг тодорхойлсон хэдий ч байгууллагын стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үр дүнд суурилсан арга хэмжээнээс илүү өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа, аж ахуйн шинжтэй ажлуудыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд түлхүү тусгасан байна.

Үүний улмаас гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллагын бодлого, стратегийн зорилго, үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй бүрэн уялдахгүй, гүйцэтгэлийн бодит үр нөлөөг үнэлэх боломж хязгаарлагдсан байна. Иймд төлөвлөлтийн чанарыг сайжруулж, үр дүнд суурилсан, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт бүхий арга хэмжээг төлөвлөх, өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс ялган төлөвлөх шаардлагатай гэж үзэж байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгууллагын стратеги төлөвлөгөө, нэгжийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, албан тушаалын чиг үүрэг болон бусад холбогдох бодлогын баримт бичигтэй уялдуулан тухайн жилийн зорилт, хүрэх түвшин, хүлээгдэж буй үр дүнг бодитой төлөвлөх
2. Зорилт, арга хэмжээг тодорхой, хэмжигдэхүйц, хүрэх боломжтой, үр дүнд чиглэсэн (SMART) зарчимд нийцүүлэн боловсруулж, хэрэгжилтийн үр дүнг илэрхийлэх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг бодитой тогтоох
3. Гүйцэтгэлийн хэрэгжилтийг бодитой үнэлэх боломжийг хангах зорилгоор шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлал, нотлох баримтыг урьдчилан тодорхойлж, шаардлагатай баримт бичгийг бүрэн бүрдүүлэх
4. Төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээ бүрийн хэрэгжүүлэх хугацаа, хариуцагчийг тодорхой зааж, давхардсан болон ерөнхий агуулгатай зорилтыг нэгтгэн оновчтой төлөвлөх
5. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, хэрэгжилтийн явц, орчны өөрчлөлтөд үндэслэн шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөг тухай бүр шинэчлэн, хэрэгжилтийн үр нөлөөг хангаж ажиллах
6. Орон нутгийн нисэх буудлуудын агаарын навигацийн үйлчилгээ болон нисэх буудлын үйлчилгээний онцлогт нийцсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний жишиг загвар боловсруулан баталж, төлөвлөлтийг нэгдсэн загвар, аргачлалын дагуу хэрэгжүүлж ажиллах
7. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд стратегийн ач холбогдолгүй, өдөр тутам давтагддаг хэвийн чиг үүргийн ажлыг тусгахгүй байж, байгууллагын зорилт, үр дүнд чиглэсэн ажлыг төлөвлөх

ТАНИЛЦСАН:

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Э.НАРАНТУНГАЛАГ

ХЯНАСАН:

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН МЕНЕЖЕР Н.БАТТӨР

ҮНЭЛСЭН:

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР Г.НАРАНЧИМЭГ

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР Б.НАНЖИД

ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР Ч.ШҮРЭНХҮҮ